

ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨЛЛИЙН ШИНЖИЛГЭЭ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү үнэлгээг СЗХ-оос боловсруулсан Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зүйл, заалтад Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг илрүүлэн, хуулийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад зөвлөмж өгөх зорилгоор гүйцэтгэлээ.

Үнэлгээ хийхээр сонгож авсан хуулийн төсөл нь Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл буюу Даатгалын зуучлалын тухай хуулийн төсөл хэлбэрээр боловсруулагдсан байна.

Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн төслийн /цаашид “хуулийн төсөл” гэх/ үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”-д /цаашид “Аргачлал” гэх/ заасны дагуу дараах үе шатаар хийлээ.

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан Аргачлалын 2.9-д заасныг үндэслэн 6 шалгуур үзүүлэлтээс дараах 4 шалгуур үзүүлэлтийг сонголоо.

Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал;
2. Практикт хэрэгжих боломж;
3. Ойлгомжтой байдал;
4. Харилцан уялдаа зэрэг болно.

Шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл:

Зорилгод хүрэх байдал:

Энэхүү үнэлгээний үндсэн зорилго нь тухайн хуулийн төслийн зохицуулалт анх дэвшүүлсэн зорилго буюу тулгамдсан бэрхшээлийг шийдвэрлэж чадах эсэхийг тогтоох билээ. Иймд хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийн үзэл баримтлал буюу хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц зохицуулалтын хувилбарыг агуулсан эсэхийг тогтоох зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

Практикт хэрэгжих боломж:

Хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдсан даатгуулагч иргэдтэй шууд харилцдаг, даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг борлуулдаг даатгалын брокер, банк-зуучлагч болон даатгалын төлөөлөгчийн эрх, үүргийг тодорхой болгон, тавигдах шаардлагуудыг тусган, мэргэшүүлэн, нарийвчилсан зохицуулалтыг бий болгон хуулийн нэрийг өөрчилсөн. Мөн даатгалын хохирол үнэлэгчийн зохицуулалтыг Даатгалын тухай хууль руу шилжүүлсэн. Даатгалын төлөөлөгчид олгож байгаа тусгай зөвшөөрлийн шаардлагыг хасаж энгийн зөвшөөрөл олгохоор болж, нэг даатгагчийг төлөөлөх зөвшөөрлийг иргэнд, хэд хэдэн даатгагчийг төлөөлөх зөвшөөрлийг хуулийн этгээдэд олгохоор болсон.

Иймд эдгээр шинэлэг зохицуулалт нь хэрэгжих боломжтой эсэхийг тодруулах шаардлагатайг харгалзан тус шалгуур үзүүлэлтийг сонгосон.

Ойлгомжтой байдал:

Хуулийн зохицуулалт нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектийн хувьд ойлгомжтой байх нь хэрэгжилтийн үр дүнд шууд нөлөөлдөг.

Хуулийн төсөл нь бүтэц, хэлбэрийн хувьд логик дараалалтай, хэл зүй, найруулгын хувьд тодорхой, ойлгоход хялбараар томъёологдсон байх шаардлага тавигддаг тул хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянан тогтоох зорилгоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

Харилцан уялдаа:

Хуулийн төслийн эх бичвэр нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжтой, мөн төсөлд тусгагдсан зохицуулалт нь өөр хоорондоо зөрчилгүй байх, хуулиар үүрэг хүлээсэн субъектүүдийн чиг үүрэг давхардал, зөрчилдөөнгүй байх шаардлагатай.

Иймд хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан агуулгын шаардлагыг хангасан эсэхийг шалгах зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгож байна.

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал болон зардал тооцох” шалгуур үзүүлэлтийг сонгоогүй тухай:

Манай улсын хувьд 2004 онд батлагдсан Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулиар даатгалын зуучлагч, төлөөлөгч, хохирол үнэлэгчийн эрх зүйн байдлыг тогтоон, холбогдох харилцааг зохицуулж ирсэн.

Гэвч даатгалын зуучлал болон хохирол үнэлэгчийн үйл ажиллагааны олон улсын чиг хандлага, даатгалын мэргэжлийн оролцогчийн талаарх олон нийтийн буруу ойлголт зэргээс үүдэн даатгалын зуучлал, хохирол үнэлэгчийн зохицуулалтыг нарийвчлах, улмаар хуулийн зохицуулалтыг сайжруулан шинэчлэн найруулах шаардлага тулгарсан.

Хуулийн төслийн үзэл баримтлал, төслийн зорилт, зохицуулалтаас үзэхэд даатгалын бүтээгдэхүүнийг зуучлан борлуулахтай холбоотой этгээдүүдийн зохицуулалт хэвээр хадгалагдах, даатгалын хохирол үнэлэгчийн зохицуулалтыг Даатгалын тухай хуулиар зохицуулахаар байна.

Иймд хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтын хүрээнд хамрагдах этгээд (иргэн, хуулийн этгээд) хүлээн зөвшөөрөх эсэхийг тодруулах зорилт бүхий **“хүлээн зөвшөөрөгдөх байдал”** шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийх шаардлагагүй гэж үзсэн болно.

Мөн дээрх үндэслэлээс гадна тухайн хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардлын тооцоог тусгайлан хийхээс гадна материаллаг зардал гарахааргүй байх тул цаг хугацаа, нөөцийн хэмнэлт хийх үүднээс **“зардал тооцох”** шалгуур үзүүлэлтийг сонгоогүй болно.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үр нөлөөг үнэлэхэд хамруулах хэсэг, түүнийг шалгах хэрэгслийг дараах байдлаар тогтоолоо.

Хүснэгт-1

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн холбогдох зохицуулалт	Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангах эсэхэд дүн шинжилгээ хийх.
2	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төслийн 3, 7, 8, 16, 17, 19, 33 дүгээр зүйл	Хуулийн зохицуулалтад хамрагдах байгууллагын төлөөлөлтэй ярилцлага зохион байгуулах, статистик мэдээ, хуулийн төсөлд ирүүлсэн саналуудад дүн шинжилгээ хийх.
3	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах.
4	Харилцан уялдаа	Хуулийн төслийг зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.5, 29.1.7, 29.1.10-т болон Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурыг хангасан шалгах.

1. Зорилгод хүрэх байдлыг хангасан эсэх:

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад тухайн хуулийн төслийн зорилго, зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийхийг зорьсон.

Энэ дагуу хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл баримтлал болон хуулийн төслийн зорилго, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийлээ.

Хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийн бүтэц, зохицуулах зүйлийн хүрээ, агуулгад дүн шинжилгээ хийж үзвэл хуулийн зохицуулалтыг нарийвчлан, дараах зорилтуудад тулгуурлан шинэчлэхээр зорьсон байна:

1. Хуулийн нэрийг “Даатгалын зуучлалын тухай хууль” гэж өөрчилж, даатгалын зуучлалын үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндсийг бүрдүүлэх;
2. Даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаанд тавих хяналт, зохицуулалтын асуудлыг холбогдох хуульд шилжүүлэх;
3. Даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрлийн шаардлагыг хасаж, энгийн зөвшөөрөл олгох зохицуулалттай болгох;
4. Хуулийн нэр томъёоны тодорхойлолтыг сайжруулж, шинээр “банк-зуучлагч”, “даатгалын зуучлалын үйл ажиллагаа”, “хамтын даатгал”, “холбогдох этгээд” тодорхойлолт нэмэх;
5. Даатгалын зуучлагч, төлөөлөгчийн хариуцлага, мэргэшсэн байдлыг нэмэгдүүлэх зохицуулалтуудыг бий болгох;
6. Даатгалын үнэлгээ ихтэй гэрээний хувьд нэг даатгагч дангаар даатгах боломжгүй тохиолдолд бусад даатгалын компанид хамтрах санал гаргахыг үүрэг болгох, гадаадын даатгагчид шууд зуучлахыг тодорхой хэмжээнд хязгаарлах замаар дотоодын даатгагчдыг дэмжих;
7. Давхар даатгалын зуучлалын зохицуулалтыг тусгах;
8. Даатгалын орлогын шимтгэлтэй холбогдох асуудлыг шийдвэрлэх, шударга өрсөлдөөнийг дэмжих зохицуулалтуудыг тусгах;
9. Даатгалын зуучлалын үйл ажиллагаанд цахим буюу дэвшилтэд техник, технологи, програм хангамж ашиглахтай холбогдох зохицуулалтуудыг бий болгох;

Дээр дурдсан зорилтуудыг хангах чиглэлээр тодорхой зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан байдлыг шалгаж үзвэл:

Хуулийн нэрийг “Даатгалын зуучлалын тухай хууль” гэж өөрчилж, даатгалын зуучлалын үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндсийг бүрдүүлэх хүрээнд:

Хуулийн зохицуулалтаас даатгалын мэргэжлийн оролцогчийн эрх зүйн зохицуулалтыг Даатгалын тухай хууль руу шилжүүлсэнтэй холбоотойгоор хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1.1-д хуулийн зорилт, 3 дугаар зүйлийн 3.2.1-д даатгалын

зуучлалын үйл ажиллагааг, 3.2.2-д даатгалын зуучлагчийг, 3.2.4-д банк-зуучлагчийг, 3.2.3-т даатгалын брокерыг, 3.2.5-д даатгалын төлөөлөгчийг тус тус тодорхойлж бусад холбогдох өөрчлөлтүүдийг оруулсан.

Ийнхүү хуулийн төслөөр даатгуулагч иргэдтэй шууд харьцдаг даатгалын зуучлалын үйл ажиллагааг илүү нарийвчлан зохицуулах эрх зүйн зохицуулалтыг тусгасан.

Даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаанд тавих хяналт, зохицуулалтын асуудлыг холбогдох хуульд шилжүүлэх хүрээнд:

Хуулийн зохицуулалтаас даатгалын мэргэжлийн оролцогчийн эрх зүйн зохицуулалтыг Даатгалын тухай хууль руу шилжүүлсэнтэй холбоотойгоор хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1.1-д хуулийн зорилт, 3 дугаар зүйлийн 3.2.1-д даатгалын зуучлалын үйл ажиллагааг, 3.2.2-т даатгалын зуучлагчийг, Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 4.1.13-т даатгалын хохирол үнэлэгчийг тус тус тодорхойлж бусад холбогдох өөрчлөлтүүдийг оруулсан.

Даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрлийн шаардлагыг хасаж, энгийн зөвшөөрөл олгох зохицуулалтын хүрээнд:

Даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрлийн шаардлагыг хасаж, нэг даатгагчийг төлөөлөх энгийн зөвшөөрлийг иргэнд, хэд хэдэн даатгагчийг төлөөлөх энгийн зөвшөөрлийг хуулийн этгээдэд олгохоор хуулийн төсөлд даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх энгийн зөвшөөрөл хүсэх хүсэлт гаргах, зөвшөөрөл олгох, олгохоос татгалзах, хориглохтой холбогдох зохицуулалт тусгагдсан.

Хуулийн нэр томьёоны тодорхойлолтыг сайжруулах хүрээнд:

Хуулийн төслийн 3.2-т нэр томьёоны тодорхойлолтыг тусгасан бөгөөд даатгалын зуучлалын үйл ажиллагаа, даатгалын зуучлагч, даатгалын брокер, даатгалын төлөөлөгч, банк-зуучлагч, гадаадын даатгалын брокер, хамтын даатгал, холбогдох этгээд зэрэг нэр томьёог шинэчлэн сайжруулж томьёолсон.

Даатгалын зуучлагч, төлөөлөгчийн хариуцлага, мэргэшсэн байдлыг нэмэгдүүлэх зохицуулалтуудыг бий болгох хүрээнд:

Хуулийн төслийн 8 дугаар зүйлд тулд даатгалын брокерын үйл ажиллагааг ердийн даатгалын брокер, амьдралын даатгалын брокер, давхар даатгалын брокер гэж 3 ангилсан.

Мөн хуулийн төслийн 7 дугаар зүйлд даатгалын зуучлагчийн эрх, үүргийг нарийвчлан тусгасан бөгөөд даатгуулагчийн эрх ашгийг хамгаалсан зохицуулалтыг тусгасан.

Даатгалын үнэлгээ ихтэй гэрээний хувьд нэг даатгаагч дангаар даатгах боломжгүй тохиолдолд бусад даатгалын компанид хамтрах санал гаргахыг үүрэг болгох, гадаадын даатгаагчид шууд зуучлахыг тодорхой хэмжээнд хязгаарлах замаар дотоодын даатгаагчдыг дэмжих хүрээнд:

Хуулийн төслийн 15 дугаар зүйлд хамтын даатгалын үйл ажиллагаанд даатгалын брокерын оролцох эрх зүйн орчныг бүрдүүлсэн.

Давхар даатгалын зуучлалын зохицуулалтыг тусгах хүрээнд:

Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.2.3-т даатгалын брокерын үйл ажиллагааг төрөлжүүлснээр давхар даатгалын брокерт тавигдах шаардлага тодорхой болж журмаар зохицуулах боломж бүрдэнэ.

Даатгалын орлогын шимтгэлтэй холбогдох асуудлыг шийдвэрлэх, шударга өрсөлдөөнийг дэмжих хүрээнд:

Хуулийн төслийн 7 дугаар зүйлд даатгалын зуучлагчийн эрх, үүргийг нарийвчлан тусгасан бөгөөд даатгуулагчийн эрх ашгийг хамгаалсан зохицуулалтыг тусгасан ба хуулийн төслийн 30 дугаар зүйлд Хороо даатгалын ангилал, хэлбэр, төрлөөс хамааран даатгагчаас даатгалын зуучлагчид олгох борлуулалтын хөлс, орлогын шимтгэлийн хувь хэмжээ, хязгаарыг тогтоож болох зохицуулалт тусгасан.

Даатгалын зуучлалын үйл ажиллагаанд цахим буюу дэвшилтэт техник, технологи, програм хангамж ашиглах хүрээнд:

Аливаа этгээд санхүүгийн үйлчилгээнд шинээр нэвтэрч буй технологид суурилсан шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнес загварыг Сэндбоксын зохицуулалтын орчинд туршсаны үндсэн дээр даатгалын зах зээлд нэвтрүүлж, үйл ажиллагаагаа цахим хэлбэрээр эрхэлж болох талаар зохицуулалтыг хуулийн төслийн 16 дугаар зүйлд тусгасан.

2. Практикт хэрэгжих боломжтой эсэх:

Хуулийн төслийн 3, 7, 8, 15, 16, 18, 32 дугаар зүйлд заасан зохицуулалтуудыг “**Практикт хэрэгжих боломж**” шалгуур үзүүлэлтээр шалган бодит байдалд хэрэгжих боломжтой эсэх, хэрэгжүүлэгч субъектүүдэд ачаалал, бэрхшээл учруулах эсэх, учирч болох эрсдэлийг буруулах арга зам байгаа эсэхийг тодруулахыг зорилоо.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн зохицуулалт:

Хуулийн төслийн 3 дугаар зүйлд даатгалын хохирол үнэлэгчийн эрх зүйн зохицуулалтыг Даатгалын тухай хууль руу шилжүүлэхтэй холбоотойгоор нэр

томъёоны тодорхойлолтоос хассан бөгөөд зөвхөн даатгалын брокер, банк-зуучлагч, даатгалын төлөөлөгчийн нэр томъёоллыг тусгасан. Мөн даатгалын зуучлалын үйл ажиллагаа болон даатгалын зуучлагчийг дараах байдлаар тодорхойлсон:

- “даатгалын зуучлалын үйл ажиллагаа” гэж даатгалын зуучлагч даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээг борлуулах болон хэлцэл хийх этгээдтэй холбож өгөх үйл ажиллагааг;
- “даатгалын зуучлагч” гэж даатгалын брокер, банк-зуучлагч, даатгалын төлөөлөгчийг;
- “банк-зуучлагч” гэж банк өөрийн харилцагчдад даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээг зуучлан борлуулах, хэлцэл хийх этгээдтэй холбож өгөх, үүнийхээ төлөө хөлс авах эрхтэй, даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий банкийг;

Даатгалын компани, давхар даатгагч, даатгалын актуарч, даатгалын аудитор, даатгалын андеррайтер нь бүгд даатгалын мэргэжлийн оролцогчид хамаарах атал Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулиар даатгалын зуучлагч, төлөөлөгч, хохирол үнэлэгчийг зөвхөн даатгалын мэргэжлийн оролцогчид хамааруулж байгаа нь даатгалын байгууллагууд, даатгуулагч, иргэд, олон нийтэд буруу ойлголтыг хүргэж байгаа тул даатгалын хохирол үнэлэгчийн зохицуулалтыг Даатгалын тухай хууль руу шилжүүлснээр энэхүү хуулиар зөвхөн даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээг иргэд олон нийтэд зуучлан борлуулдаг дундын зуучлалын үйл ажиллагааг тусгайлан, нарийвчлан зохицуулах боломж бүрдэж байгаа нь практикт хэрэгжих боломжтой юм.

Мөн даатгалын бүтээгдэхүүнийг худалдан борлуулж, даатгуулагч иргэдтэй шууд харилцдаг даатгалын зуучлагч, төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэр дундаа даатгуулагчийн олгосон эрхийн хүрээнд түүний ашиг сонирхлын төлөө даатгалын гэрээний харилцаанд оролцож буй даатгалын зуучлагчийн үйл ажиллагааг боловсронгуй, мэргэшсэн түвшинд байлгах, энэхүү дундын зуучлагчдын зах зээлийг илүү ёс зүйтэй, ил тод, шударга өрсөлдөөнтэй зах зээл болгон хөгжүүлэх хүрээнд “Insurance intermediaries Act” буюу “Даатгалын зуучлалын хууль”-ийг олон улсад батлан мөрдүүлдэг байна.

Хуулийн төслийн 7 дугаар зүйлийн зохицуулалт:

Хуулийн төслийн 7 дугаар зүйлд даатгалын зуучлагчийн эрх, үүргийг тодорхой болгон тусгасан бөгөөд дараах байдлаар томъёолсон:

- Даатгалын зуучлагч нь дараах эрх эдэлнэ:

- даатгуулагчаас үнэн зөв, бүрэн, бодит мэдээлэл авах;
- даатгагч болон даатгуулагчаас зуучлалын үйл ажиллагааны хөлс, шимтгэл авах;

- хууль тогтоомжид заасан бусад эрх.
- Даатгалын зуучлагч нь дараах үүрэг хүлээнэ:
 - даатгалын зуучлалын үйл ажиллагааг мэргэжлийн, нээлттэй, ёс зүйтэй гүйцэтгэх;
 - ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөлд үйлчлүүлэгчид энэ талаар мэдэгдэх;
 - даатгалын гэрээ байгуулахаас өмнө болон даатгалын гэрээний хугацаанд даатгалын мэргэжлийн зөвлөгөө өгөх, үйлчилгээ үзүүлэх;
 - даатгалын гэрээний нөхцөлийг даатгуулагчид энгийн ойлгомжтой түвшинд тайлбарлан өгөх, мэдээлэл авах нөхцөл боломжоор хангах;
 - даатгалын гэрээ болон хураамж төлсөн баримтыг даатгуулагчид бичгээр, эсхүл цахим хэлбэрээр олгох;
 - даатгуулагч эсвэл даатгагчтай байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол даатгалын хураамжийг хүлээн авсан даруй даатгагчид шилжүүлэх;
 - даатгалын хураамж төлөх хугацаа, гэрээний сунгалтыг даатгуулагчид гэрээнд заасны дагуу тухай бүр мэдэгдэх;
 - даатгуулагчид даатгагчаа сонгох боломжийг олгож, эрхийг хязгаарлахгүй байх, даатгалын зуучлагч нь өөрийн хамтран ажилладаг даатгагчийн бүтээгдэхүүн үйлчилгээг тулгахгүй байх;
- хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд даатгалын зуучлагчийн эрх, үүрэг тусгагдаагүй байсан тул эрх үүрэг тодорхой болсноор нийгэмд учрах үл ойлголцол, гомдол маргаан буурах тул практикт хэрэгжих боломжтой.

Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн зохицуулалт:

Хуулийн төслийн 8 дугаар зүйлд даатгалын брокерын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл болон үйл ажиллагааны ангиллыг дараах байдлаар тусгасан:

- Даатгалын брокерын үйл ажиллагааг Хорооноос зөвшөөрөл авсан компани эрхэлнэ.
- Даатгалын брокерын үйл ажиллагаа нь дараах ангилалтай байна:
 - ердийн даатгалын брокер;

- амьдралын даатгалын брокер;

- давхар даатгалын брокер.

- Даатгалын брокер нь энэ хуулийн 8.2-т заасан ангиллын дагуу даатгалын брокерын үйл ажиллагааг дангаар нь эрхэлнэ.

Даатгалын брокерын үйл ажиллагааг ангилснаар брокер нь илүү мэргэшүүлэх эрх зүйн орчин нийгэмд болон практикт хэрэгжинэ.

Хуулийн төслийн 15 дугаар зүйлийн зохицуулалт:

Хуулийн төслийн 15 дугаар зүйлд даатгалын брокер хамтын даатгалын үйл ажиллагаанд оролцохыг дараах байдлаар тусгасан:

- Даатгалын брокер нь Даатгалын тухай хуулийн 4.1.17-д заасан хамтын даатгалын үйл ажиллагааг зохион байгуулахад оролцож болно.

- Даатгалын брокер нь хамтын даатгалын үйл ажиллагааг зохион байгуулах тохиолдолд тухайн даатгалын брокерын зохион байгуулалтын энэхүү үүрэг нь хамтын даатгалын гэрээ дуусгавар болсноор зогсоно.

- Даатгалын брокер хамтын даатгалын үйл ажиллагаанд оролцохтой холбогдох нарийвчилсан зохицуулалтыг Даатгалын журмаар тогтоож болно.

Даатгалын брокер нь хамтарсан даатгалын үйл ажиллагаанд оролцох боломж, эрх зүйн орчин бүрдэн нийгэм болон практикт хэрэгжинэ.

Хуулийн төслийн 16 дугаар зүйлийн зохицуулалт:

Хуулийн төслийн 16 дугаар зүйлд цахим хэлбэрээр даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхлэхийг дараах байдлаар тусгасан:

- Аливаа этгээд санхүүгийн үйлчилгээнд шинээр нэвтэрч буй технологид суурилсан шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнес загварыг Сэндбоксын зохицуулалтын орчинд туршсаны үндсэн дээр даатгалын зах зээлд нэвтрүүлж, үйл ажиллагаагаа цахим хэлбэрээр эрхэлж болно.
- Цахим хэлбэрээр даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхлэх, түүнд хяналт тавих зорилгоор Хороо журам баталж болно.

Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд цахим хэлбэрээр даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхлэх талаар зохицуулалт тусгагдаагүй байсан бөгөөд олон улсын чиг хандлагын дагуу даатгалын зуучлалын үйл ажиллагаанд дэвшилтэт технологи, цахим хэлбэрийг ашиглах боломж бүрдэж практикт хэрэгжинэ.

Хуулийн төслийн 18 дугаар зүйлийн зохицуулалт:

Даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрлийн шаардлагыг хасаж, энгийн зөвшөөрөл олгох зохицуулалтыг дараах байдлаар тусгасан:

- Хороо даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд энгийн зөвшөөрөл олгоно.

- Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа нь дараах төрөлтэй байна:

- нэг даатгагчийг төлөөлөх;

- хэд хэдэн даатгагчийг төлөөлөх.

- Энэ хуулийн 18.2.1-д заасан даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх энгийн зөвшөөрлийг иргэнд, 18.2.2-т заасан даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх энгийн зөвшөөрлийг хуулийн этгээдэд олгоно.

Хэд хэдэн даатгагчийг төлөөлөх даатгалын төлөөлөгчийн энгийн зөвшөөрлийг хуулийн этгээдэд олгохоор болсон нь банк бус санхүүгийн байгууллага, сүлжээ дэлгүүр, түц зэрэг олон нийтэд илүү түгээмэл олон салбартай хуулийн этгээд эрхэлж болохоор практикт хэрэгжинэ.

Хуулийн төслийн 32 дугаар зүйлийн зохицуулалт:

Хороо даатгалын салбарын дагаж мөрдвөл зохих зах зээлийн зохистой үйл ажиллагааны журмыг гаргаж болох талаар болон даатгалын зуучлалын үйл ажиллагаанд оролцогч болон тэдгээрийн эрх бүхий албан тушаалтан түүнийг дагаж мөрдөх үүрэгтэй талаар тусгасан.

3. Ойлгомжтой эсэх:

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг гүйцэтгэлээ.

Мөн хуулийн төсөлд холбогдох байгууллагуудаас ойлгомжтой болгох чиглэлээр ирүүлсэн санал байгаа эсэхийг нягтлан, анализ хийсэн болно.

Хуулийн төсөл нь нийт 10 бүлэг, 52 зүйлтэй болно.

Хуулийн төслийн бүтцийн дугаарлалт нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6, 28.7-д заасан хуульд заасан шаардлагыг хангасан байна.

Мөн хуулийн төслийг баталснаар дараах дагах хуулиудад нэмэлт өөрчлөлт орох төсөл боловсруулагдсан:

1. Хууль хүчингүй болсонд тооцох тухай
2. Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
3. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
4. Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

5. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
6. Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
7. Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.8-д заасан дугаарлалт болон хуулийн төслийн заалтын байршилд тавигдах шаардлагыг хангасан байна.

Бие даасан санаа бүрийг тусгай зүйлд тусгаж, заалт нь нэг өгүүлбэрээр илэрхийлэгдсэн, төслийн бүтэц нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 28.3-т заасанд нийцсэн байна.

Мөн хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх, үүнд хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх, 30 дугаар зүйлд заасан хэл зүй, найруулгын ерөнхий шаардлагад нийцсэн байна.

4.Харилцан уялдаатай байдлыг хангасан эсэх:

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь авч үзэхээр тооцлоо.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.5, 29.1.7, 29.1.10-т болон Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурын дагуу үнэллээ.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх:

Д/д	Шалгах асуулт	Шаардлагыг хангасан эсэх
1	29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх	Үндсэн хуульд заасан зарчмыг хангахад чиглэсэн бөгөөд ямар нэгэн байдлаар зөрчилдөөгүй байна.
2	29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх	Төслийн зүйл, хэсэг, заалт хоорондоо зарчмын томоохон зөрчил байхгүй байна.
3	29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх	Энэхүү хуулийн төсөлд зүйл, заалт хооронд эшлэл хэрэглэсэн байна.

4	29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх	Тус хуулийн төслийг дагаж нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулсан байна.
---	---	---

Аргачлалын 4.10-т заасан шалгуурыг хангасан эсэх:

Д/д	Асуулт	Хариулт	Дүн шинжилгээ
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Тийм	Хуулийн төслийн зохицуулалт нь үзэл баримтлалд тусгагдсан зорилтыг бүрэн хангаж байна.
2	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх	Тийм	Энэхүү шаардлагыг хангасан байна.
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх	Тийм	Энэхүү шаардлагыг хангасан байна.
4	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх	Тийм	Дүн шинжилгээний хүрээнд зарчмын зөрүүтэй ямар нэгэн асуудал илрээгүй.
5	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх	Тийм	Энэхүү шаардлагыг хангасан байна.
6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Тийм	Хуулийн төслийг хэрэгжүүлэгч субъектүүдийн эрх үүргийг ялган тодорхойлсон байна.
7	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Тийм	Энэхүү шаардлагыг хангасан байна.
8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	Үгүй	Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй.
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх	Тийм	Энэхүү зохицуулалтыг нарийвчлан тодорхой зарчмыг тогтоосон байна.
10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх	Үгүй	Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй.

11	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх	Тийм	Хуулийн төсөлд тусгасан хязгаарлалт нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн, хуульд заасан зайлшгүй бөгөөд хүний хууль ёсны ашиг сонирхлыг хуулиас гадуур хөндөхгүй байх нөхцөлийг тусгасан байна.
12	Хуулийн төслийн зүйл, заалт жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	-	Хуулийн төсөлд тусгайлан зохицуулалт тусгагдаагүй бөгөөд энэ асуудлыг Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хүрээнд зохицуулах боломжтой.
13	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	-	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдаагүй.
14	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	-	Хяналтаар энэ төрлийн зөрчил илрээгүй.
15	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.		Тухайн хуулийг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг тусгасан.

Энэхүү шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийж үзэхэд хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт өөр хоорондоо болон Монгол Улсын Үндсэн хууль, бусад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжтой зарчмын хувьд зөрчилдөөгүй, үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтнуудын чиг үүрэгт давхардал үүсгээгүй байна.

ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

Энэхүү үр нөлөө тооцох үнэлгээг Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хорооноос боловсруулсан хуулийн төсөл, хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хийлээ.

Үнэлгээнд хуулийн төсөл, үзэл баримтлалаас гадна статистик тоон үзүүлэлтүүд, тайлан мэдээлэл, холбогдох хууль тогтоомж, тэдгээрийн албан ёсны болон албан бус тайлбар, санал зэрэг нэмэлт материалыг ашигласан болно.

Хуулийн төсөл нь дэвшүүлсэн зорилгоо хангасан эсэх, практикт хэрэгжих боломжтой эсэх, бусад хуулиудтай хэрхэн уялдсан, хуулийн төслийн найруулга, хэл

зүй ойлгомжтой эсэх гэсэн шалгуур үзүүлэлт тус бүрийн дагуу хийсэн үнэлэлтийг нэгтгэн дараах Дүгнэлтийг боловсрууллаа:

Дүгнэлт:

Зорилгод хүрэх байдал: Хуулийн төсөл нь үзэл баримтлалд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн, холбогдох зохицуулалтыг тусгасан байна.

Практикт хэрэгжих боломжийг хангасан байдал: Хуулийн төсөлд даатгалын зуучлагчийн эрх, үүргийг тодорхой болгож, даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрлийн шаардлагыг хасаж энгийн зөвшөөрөл олгох зохицуулалтыг тусгаж, үйл ажиллагаанд цахим хэлбэрийг ашиглах болон даатгалын брокер хамтарсан даатгалын үйл ажиллагаанд оролцох боломжийг олгосон, даатгалын зуучлагчийн үйл ажиллагааны зохистой байдлыг хангах зохицуулалтыг тусгасан нь сайшаалтай байна.

Ойлгомжтой байдал: Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан хэлбэрээр боловсруулагдсан ойлгомжтой байна.

Харилцан уялдааг хангасан байдал: Хуулийн төслийн зүйл заалт өөр хоорондоо болон Үндсэн хуультай зарчмын хувьд зөрчилдөөгүй, үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтны чиг үүрэгт давхардал үүсгээгүй байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

Судалгаа, статистик мэдээлэл

1. Даатгалын зуучлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл. 2024 он. СЗХ
2. Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, танилцуулга. 2024 он. СЯ, СЗХ
3. Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагаж нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслүүд. 2024 он. СЗХ
4. Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийг шинэчлэн найруулах хэрэгцээ, шаардлага, Тандан судалгаа хийсэн үнэлгээ. 2024 он. СЗХ

Хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, тушаалын жагсаалт

1. Хууль тогтоомжийн тухай хууль;
2. Зөрчлийн тухай хууль;
3. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль;
4. Зөвшөөрлийн тухай хууль;
5. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль;
6. Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль;
7. Банкны тухай хууль